

**ТЭРГҮҮН ШАДАР САЙД
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД**

САНГИЙН САЙД

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Н.УЧРАЛ

Б.ЖАВХЛАН

Л.МӨНХБААТАР

**ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтад “дунд хугацаа” гэж дараа жилийн болон түүний дараах дараалсан хоёр жилийг хамарсан төсвийн гурван жилийг” гэж, 4.1.10 дахь заалтад “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл” гэж тухайн төсвийн жилийн хүлээгдэж байгаа макро эдийн засгийн болон төсвийн гүйцэтгэлийн төлөв байдал, дунд хугацааны макро эдийн засгийн ба төсвийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөлд суурилсан төсвийн бодлогын баримт бичгийг” гэж, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ.” гэж, мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, түүний нэмэлт, өөрчлөлтийг баталснаас хойш гурваас доошгүй сарын хугацаанд харгалзах тухайн жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэх, батлахыг хориглоно.” гэж, тус зүйлийн 7.6 дахь хэсэгт “Гамшгийн аюулын хор уршиг, онцгой нөхцөлийн үр дагаврыг арилгах зорилгоор болон Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбоотойгоор жилийн төсөв болон төсвийн тодотгол батлах бол энэ хуулийн 7.5-д заасан хязгаарлалт хамаарахгүй.” гэж тус тус заасан.

Түүнчлэн Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.5 дахь заалтад “Засгийн газар жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 01-ний дотор Төрийн аудитын байгууллагад хүргүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж заасан.

Макро эдийн засгийн болон төсвийн төлөв байдал, цаашдын хандлага, төсөөлөлд үндэслэн 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн

төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага үүссэн хэдий ч тус хуульд 2025 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс хойш өөрчлөлт орсон тохиолдолд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газар жилийн төсвийн төслийг 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх боломжгүй болох нөхцөл үүсэхээр байна.

Иймд макро эдийн засгийн болон төсвийн гүйцэтгэлийн төлөв байдал, дунд хугацааны эдийн засгийн болон төсвийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөлд үндэслэн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ болон нийт зарлагын дээд хэмжээг бууруулах өөрчлөлт оруулсантай холбогдуулан жилийн төсөв болон төсвийн тодотголын төслийг батлах бол Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт заасан хязгаарлалт хамаарахгүй байх боломжийг бүрдүүлэх зорилгоор тус хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Практик шаардлага

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг 2025 оны 4 дүгээр сард боловсруулах үед Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 12 тоот албан бичгээр нэг тонн нүүрсний экспортын үнийг 2025 онд 85 ам.доллар, 2026 онд 88 ам.доллар, 2027 онд 92 ам.доллар, 2028 онд 96 ам.доллар байх таамаглал ирүүлсэн. Тухай үеийн олон улсын зах зээлийн нөхцөл байдал, мэргэжлийн шинжээчдийн боловсруулан зарласан төсөөлөл зэргийг харгалзан нүүрсний үнийн төсөөллийг тус зөвлөлөөс ирүүлсэн төсөөллөөс бууруулж, 2025 болон 2026 онд 80 ам.доллар, 2027 болон 2028 онд 77 ам.доллар байхаар тус тус тооцож, макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөлд ашигласан.

Гэвч Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш зарлагдсан статистик мэдээллээр манай улсын экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний экспортын үнэ 2025 оны эхний 5 сард дунджаар 72 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 39 хувиар, нийт экспорт 2025 оны эхний 5 сард 5.4 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 15 хувь буюу 931 сая ам.доллороор, төсвийн нийт орлого 11.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 11 хувь буюу 1.3 их наяд төгрөгөөр тус тус буурсан. Мөн эдийн засгийн өсөлт 2023 онд 7.4 хувь, 2024 онд 4.9 хувь байсан бол 2025 оны эхний улиралд 2.4 хувь болж буурсан. Экспорт, төсвийн орлого буурч, эдийн засгийн өсөлт саарсны улмаас төсвийн орлого дунд хугацаанд бидний төсөөлснөөс бага байх эрсдэл өндөр байна.

Улсын Их Хурлаас Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2025 оны 6 дугаар сард баталж, улмаар төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх шаардлага үүссэнээр Засгийн газар 2025 оны төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Мөн Засгийн газраас Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Тус хуулийн төсөлд нэгдсэн төсвийн 2025 оны тэнцвэржүүлсэн орлогыг 3.3 их наяд төгрөгөөр, нийт зарлагыг 1.9 их наяд төгрөгөөр тус тус бууруулахаар тусгасан. Нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулахтай уялдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026-2027 оны төсвийн төсөөлөл өөрчлөгдөх, улмаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд холбогдох өөрчлөлт оруулах шаардлага үүсээд байна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэх, олон улсын геополитикийн нөхцөл байдал, худалдаа, эдийн засгийн тодорхойгүй байдлын улмаас учрах эдийн засгийн эрсдэлийг хязгаарлах зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах бөгөөд хуулийн төсөлд “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ болон нийт зарлагын дээд хэмжээг бууруулах өөрчлөлт орсонтой холбогдуулан жилийн төсөв, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлахад энэ хуулийн 7.5-д заасан хязгаарлалт хамаарахгүй байхаар” тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар жилийн төсөв болон төсвийн тодотголыг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нөхцөл бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн бөгөөд бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

--o0o--